



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2014 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 166

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг сэргээх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн 352 тоот тогтоол, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гүйцэтгэх захирлын 2014 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн 117 дугаар тушаал, 2014 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн I/421 тоот мэдэгдэл, “Бага хээр” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн арилжаанд оролцох эрхийг сэргээлгэх тухай хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Бага хээр” ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 10 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. Цаашид хууль тогтоомж, журам заавар болон “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанитай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлэн ажиллахыг “Бага хээр” ХХК /Б.Наранцэцэг/-т анхааруулсугай.
3. Тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагааны газар /М.Энхтуяа/-т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д. АНГАР